



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хашаат сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/05-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.Open.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Аудитор Н.Энхчимэг
Цахим хаяг: Enkhchimeg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.14 № 08

танай _____-ны № _____-г

ХАШААТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА А.АРИУНБУЯН
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хашаат сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Хашаат сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Албан хаагчдад олгосон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны урамшууллаас хувь хүний орлогын татвар 2,257.8 мянган төгрөгийг суутган авч төсөвт төвлөрүүлээгүй;
2. Малжуулах төслөөр 2022 онд 5 иргэнд олгосон 11,980.0 мянган төгрөгийн зээлийн авлагыг барагдуулаагүй, гэрээний хугацааг хэтрүүлсэнд холбогдох арга хэмжээг аваагүй;
3. Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолоор баталсан сумын Засаг даргын тамгын газрын бүтэц орон тооны дээд хязгаараас үйлчилгээний 2 орон тоог илүү баталж цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд 14,218.3 мянган төгрөг олгож төсвийг хэмнэлтгүй зарцуулсан;

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.1.1, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтууд, Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоол, "Малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэгийн гэрээ"-ний 1.2, 2.6, 2.7 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 83 дугаар тогтоолоор "Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам" батлагдаж 22,577.8 мянган төгрөгийг хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласны урамшуулалд зарцуулсан байна

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал бусад, орон нутгийн нөөц хөрөнгө, байгаль орчин нөхөн сэргээх, хамгаалах, гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа, улсын баяр наадам гэсэн 7 арга хэмжээг хэрэгжүүлэх 1,052,861.7 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 974,379.8 мянган төгрөгийг зарцуулж 79,481.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн үлдэгдэл нь орон тоо дутуу ажилласнаас шалтгаалсан байна.

Бусад асуудлын хэсэг

Хашаат сумын ЗДТГ нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 15 үндсэн зорилтын хүрээнд 90 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 63 арга хэмжээг 100 хувь, 16 арга хэмжээ 90 хувь, 8 арга хэмжээг 70 хувь 1 арга хэмжээ 50 хувь, 2 арга хэмжээг 30 хувь биелүүлж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын Засаг даргаас 95.5 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	92,922,981.39	63,430,370.00
33	АВЛАГА	41,270,000.00	11,980,000.00
335	Бусад авлага	41,270,000.00	11,980,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	41,270,000.00	11,980,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	51,652,981.39	51,450,370.00
354	Хангамжийн материал	51,652,981.39	51,450,370.00
3541	Бичиг хэргийн материал	3,761,610.00	3,321,810.00
3542	Аж ахуйн материал	31,017,671.39	36,714,860.00
3544	Түлш, шатах тослох материал	2,670,000.00	6,180,000.00
3545	Барилгын засварын материал	247,700.00	457,700.00
3547	Бусад хангамжийн материал	13,956,000.00	4,776,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,617,604,439.31	2,068,033,198.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,617,604,439.31	2,068,033,198.70
392	Биет хөрөнгө	1,575,863,439.31	2,026,367,198.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	771,707,806.18	779,498,826.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	-100,561,584.70	-111,725,387.30
39203	Авто-тээврийн хэрэгсэл	192,937,550.00	333,974,815.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-101,274,067.54	-66,947,780.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	204,159,675.00	243,887,995.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-80,731,039.71	-96,992,630.23
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,852,164.00	26,941,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,203,113.37	-19,911,825.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,239,754,635.11	1,580,578,266.11
39215	Хуримтлагдсан элэгдэл	-560,193,085.66	-643,350,580.42
39217	Ном	414,500.00	414,500.00
393	Биет бус хөрөнгө	41,741,000.00	41,666,000.00
39301	Програм хангамж	6,200,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6,125,000.00	-750,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	41,666,000.00	41,666,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,710,527,420.70	2,131,463,568.70
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,710,527,420.70	2,131,463,568.70
51	Засгийн газрын хувь оролцоо	1,710,527,420.70	2,131,463,568.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	576,458,170.68	576,458,170.68
51101	Өмч: - төрийн	576,458,170.68	576,458,170.68
512	Хуримтлагдсан үр дүн	921,084,200.84	1,342,020,348.84
5121	Өмнөх үеийн үр дүн	921,084,200.84	921,084,200.84
5122	Тайлант үеийн үр дүн		420,936,148.00
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	212,985,049.18	212,985,049.18
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,710,527,420.70	2,131,463,568.70

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,181,664,508.00	1,540,941,095.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	411,957,344.00	472,136,746.00
120	Нийтлэг татварын бус орлого	411,957,344.00	472,136,746.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,121,000.00	3,861,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,121,000.00	3,861,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	409,836,344.00	468,275,246.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	769,707,164.00	1,068,804,349.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,370,064.00	16,102,649.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,087,064.00	1,872,649.00

Архангай аймгийн Хашаат сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	65,283,000.00	9,180,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	698,337,100.00	1,052,701,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	698,337,100.00	1,052,701,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	766,033,805.46	1,099,004,947.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	758,326,805.46	1,093,841,347.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	677,770,193.00	938,410,279.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,285,407.00	532,227,073.00
210101	Үндсэн цалин	245,492,412.00	345,775,458.00
210102	Нэмэгдэл	67,171,954.00	171,585,575.00
210104	Урамшуулал	35,621,041.00	14,866,040.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,293,484.00	65,640,929.69
210201	Тэтгэврийн даатгал	30,052,334.81	45,440,245.77
210202	Тэтгэмжийн даатгал	3,535,568.76	5,345,911.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,793,254.93	2,746,829.98
210204	Ажилгүйдлийн даатгал	618,777.17	2,351,927.78
210205	Эрүүл мэндийн даатгал	6,293,548.33	9,756,014.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,998,914.20	18,055,901.89
210301	Гэрэл, цахилгаан	8,602,414.20	9,521,901.89
210302	Түлш, халаалт	8,396,500.00	8,534,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,099,868.44	33,316,865.89
210401	Бичиг хэрэг	4,624,350.00	5,812,100.00
210402	Тээвэр, шатахуун	8,892,455.00	11,153,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,140,474.34	4,870,974.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,835,580.00	4,614,460.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,985,509.10	6,865,441.39
210408	Бараа материал акталсны зардал	6,621,500.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,389,400.00	12,059,800.00
210604	Урсгал засвар	3,389,400.00	12,059,800.00
2107	Томилолт, зочны зардал	13,744,000.00	16,510,000.00
210702	Дотоод албан томилолт	13,744,000.00	16,510,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,663,414.00	27,225,252.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,047,564.00	21,872,649.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,474,250.00	4,280,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	376,600.00	488,203.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	765,000.00	584,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	210,295,705.36	233,374,456.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,972,118.00	60,586,170.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	150,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	141,173,587.36	172,788,286.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,556,612.46	155,431,067.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,524,950.00	32,777,082.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		30,432,087.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,524,950.00	2,344,995.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	79,031,662.46	122,653,985.92
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,935,162.46	111,473,385.92
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	9,096,500.00	11,180,600.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,707,000.00	5,163,600.00
	Дотоод эх үүсвэрээр	7,707,000.00	5,163,600.00
221001	Их засвар	7,707,000.00	3,457,500.00
222001	Тоног төхөөрөмж		1,706,100.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	415,630,702.54	441,936,148.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.27	21,000,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.27	
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө		21,000,000.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-0.27	-21,000,000.00
V	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	415,630,702.27	420,936,148.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	730,558,164.00	1,101,955,849.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,121,000.00	33,151,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,121,000.00	33,151,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,121,000.00	33,151,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,121,000.00	33,151,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	728,437,164.00	1,068,804,349.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,100,064.00	16,102,649.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,000,000.00

Архангай аймгийн Хашаат сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,087,064.00	1,872,649.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,013,000.00	9,180,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	698,337,100.00	1,052,701,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	698,337,100.00	1,052,701,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	619,575,159.00	920,850,449.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	619,575,159.00	920,850,449.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	539,018,546.54	764,878,381.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,285,407.00	532,227,073.00
210101	Үндсэн цалин	245,492,412.00	345,775,458.00
210102	Нэмэгдэл	67,171,954.00	171,585,575.00
210104	Урамшуулал	35,621,041.00	14,866,040.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,293,484.00	65,640,929.69
210201	Тэтгэврийн даатгал	30,052,334.81	45,440,245.77
210202	Тэтгэмжийн даатгал	3,535,568.76	5,345,911.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,793,254.93	2,746,829.98
210204	Ажилгүйдлийн даатгал	618,777.17	2,351,927.78
210205	Эрүүл мэндийн даатгал	6,293,548.33	9,756,014.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,724,914.20	21,565,901.89
210301	Гэрэл, цахилгаан	8,602,414.20	9,521,901.89
210302	Түлш, халаалт	9,122,500.00	12,044,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,940,009.34	29,469,104.50
210401	Бичиг хэрэг	3,007,100.00	4,938,300.00
210402	Тээвэр, шатахуун	8,624,055.00	11,153,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,140,474.34	5,024,754.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,288,580.00	4,614,460.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,879,800.00	3,737,700.00
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,423,800.00	12,269,800.00
210604	Урсгал засвар	3,423,800.00	12,269,800.00
2107	Томилолт, зочны зардал	13,744,000.00	16,510,000.00
210702	Дотоод албан томилолт	13,744,000.00	16,510,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,663,414.00	30,225,252.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,047,564.00	24,872,649.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,474,250.00	4,280,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	376,600.00	488,203.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	765,000.00	584,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,943,518.00	56,970,320.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,793,518.00	56,970,320.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	150,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,556,612.46	155,972,067.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,524,950.00	33,318,082.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		30,432,087.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,524,950.00	2,885,995.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	79,031,662.46	122,653,985.92
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,935,162.46	111,473,385.92
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	9,096,500.00	11,180,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	110,983,005.00	181,105,400.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	110,983,005.00	181,105,400.00
	Дотоод эх үүсвэрээр		
221001	Их засвар	7,707,000.00	3,457,500.00
222001	Тоног төхөөрөмж		1,706,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	103,276,005.00	175,941,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-110,983,005.00	-181,105,400.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	576,458,170.68	212,985,049.18	921,084,200.84	1,710,527,420.70
17	Тайлант үеийн үр дүн			420,936,148.00	420,936,148.00
19	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	576,458,170.68	212,985,049.18	1,342,020,348.84	2,131,463,568.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,052,861,700.00	974,379,814.08	78,481,885.92	92.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	871,399,300.00	794,856,914.08	76,542,385.92	91.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	836,697,300.00	761,538,832.08	75,158,467.92	91.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	588,447,800.00	532,227,073.00	56,220,727.00	90.45
210101	Үндсэн цалин	588,447,800.00	345,775,458.00	242,672,342.00	58.76
210102	Нэмэгдэл		171,585,575.00	-171,585,575.00	
210104	Урамшуулал		14,866,040.00	-14,866,040.00	
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,556,000.00	65,640,929.69	7,915,070.31	89.24
210201	Тэтгэврийн даатгал	50,018,000.00	45,440,245.77	4,577,754.23	90.85
210202	Тэтгэмжийн даатгал	5,884,500.00	5,345,911.25	538,588.75	90.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,707,600.00	2,746,829.98	1,960,770.02	58.35
210204	Ажилгүйдлийн даатгал	1,176,900.00	2,351,927.78	-1,175,027.78	199.84
210205	Эрүүл мэндийн даатгал	11,769,000.00	9,756,014.91	2,012,985.09	82.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,595,400.00	21,565,901.89	29,498.11	99.86
210301	Гэрэл, цахилгаан	9,395,400.00	9,521,901.89	-126,501.89	101.35
210302	Түлш, халаалт	12,050,000.00	12,044,000.00	6,000.00	99.95
210303	Цэвэр, бохир ус	150,000.00		150,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	30,270,000.00	29,469,104.50	800,895.50	97.35
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	4,938,300.00	61,700.00	98.77
210402	Тээвэр, шатахуун	11,500,000.00	11,153,890.00	346,110.00	96.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,850,000.00	5,024,754.50	-174,754.50	103.6
	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,920,000.00	4,614,460.00	305,540.00	93.79
210405	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,000.00	3,737,700.00	262,300.00	93.44
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,450,000.00	12,269,800.00	180,200.00	98.55
210604	Урсгал засвар	12,450,000.00	12,269,800.00	180,200.00	98.55
2107	Томилолт, зочны зардал	16,554,100.00	16,510,000.00	44,100.00	99.73
210702	Дотоод албан томилолт	16,554,100.00	16,510,000.00	44,100.00	99.73
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,824,000.00	28,352,603.00	471,397.00	98.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,124,000.00	23,000,000.00	124,000.00	99.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,300,000.00	4,280,000.00	20,000.00	99.53
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	488,203.00	111,797.00	81.37
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	584,400.00	215,600.00	73.05
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,000,000.00	55,503,420.00	9,496,580.00	85.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,000,000.00	55,503,420.00	8,496,580.00	86.72
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00		1,000,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,702,000.00	33,318,082.00	1,383,918.00	96.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,702,000.00	33,318,082.00	1,383,918.00	96.01
	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,702,000.00	30,432,087.00	269,913.00	99.12
213208	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	2,885,995.00	1,114,005.00	72.15
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	181,462,400.00	179,522,900.00	1,939,500.00	98.93
	Дотоод эх үүсвэрээр	181,462,400.00	179,522,900.00	1,939,500.00	98.93
221001	Их засвар	60,462,400.00	60,457,500.00	4,900.00	99.99
222001	Тоног төхөөрөмж	121,000,000.00	116,392,400.00	4,607,600.00	96.19
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,052,861,700.00	974,379,814.08	78,481,885.92	92.55
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,052,701,700.00	941,228,314.08	111,473,385.92	89.41
132001	Орон нутгийн төсвөөс ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ	1,052,701,700.00	941,228,314.08	111,473,385.92	89.41
120004	АЖИЛЛАГААНААС Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	160,000.00	33,151,500.00	-32,991,500.00	20,719.69
1200041	санхүүжих	160,000.00	33,151,500.00	-32,991,500.00	20,719.69
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
3	Төсвийн байгууллага	1	1		100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	20	3	86.96
6	Удирдах ажилтан	8	8		100
7	Гүйцэтгэх ажилтан	9	6	3	66.67
8	Үйлчлэх ажилтан	6	6		100
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,102,649.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,102,649.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,922,049.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,872,649.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,872,649.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,049,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,049,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,180,600.00
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,180,600.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	11,180,600.00
213405	шилжүүлэг	11,180,600.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	16,102,649.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,102,649.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,050,000.00
	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00
131103	төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,872,649.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,180,000.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 31,335.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа.

Залруулсан алдаа:

- Худалдаж авсан 31,335.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг урсгал зардалд тайлагнасныг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 13.1 дэх заалт, санхүүгийн тайлангийн ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар залруулаагүй 30,386.9 мянган төгрөгийн зөрчил илэрч 2,736.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 27,650.3 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 7 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 30,386.9 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 7,370.0 мянган төгрөгөөс их байх тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Сумын Засаг даргын 2024 оны 06 сарын 05-ны өдрийн Б/09 дүгээр захирамжаар сумын ЗДТГ-ын даргад 9,466,3 мянган төгрөг, ЗДТГ-ын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Б/10 дугаар тушаалаар Малын үржил, бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэнд 6,555,8 мянган төгрөг, Байгаль орчны хяналтын улсын байцаагчид 6,555,8 мянган төгрөг нийт 22,577,859 төгрөгийг олгосноос хувь хүний орлогын албан татвар 2,257,785 төгрөгийг суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-д "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна, 7.1.1-д "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар ... албан татвар ногдуулна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1. Малжуулах төслөөр олгосон зээлийн 11,980.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй хугацаа хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэгийн гэрээ"-ний 1.2-т "А тал нь В талыг малжуулах, мал аж ахуй эрхлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор 5,000.0 мянган төгрөгийн мал худалдан авч өгөх эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг...дансанд шилжиж орсноос хойш 24 сарын дотор В тал хавсралтад тусгасан эргэн төлөлт хийх хувиар дагуу мөнгөн хэлбэрээр төлж барагдуулахаар харилцан тохиролцов", 2.6-д "Хавсралтад тусгагдсан В талын боловсруулсан эргэн төлөлт хийх хуваарийн дагуу сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн... дансанд эргэн төлөлт хийхийг шаардах эрхтэй", 2.7-д "Гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй болон удаа дараагийн зөвлөгөө,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

шаардлагыг хүлээн аваагүй тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулах арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Сумын Засаг даргын 2024 оны 10 сарын 21-ны өдрийн Б/21 дүгээр захирамжаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 зүйлийн 23.2 дахь заалтыг үндэслэн санхүү албаны даргад цалингийн сангаас нэг сарын үндсэн цалинтай тэнцэх 1,452.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, 16 дугаар зүйлийн 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

5.2.3. Сумын Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Б/12, 2024 оны 12 сарын 17-ны өдрийн Б/14, Б/15 дугаар тушаалуудаар Санхүү албаны даргад үр дүнгийн урамшууллыг олгохдоо өөрийн үндсэн албан тушаалын цалингаас хагас бүтэн жилээр 140 хувь, хавсран гүйцэтгэж байгаа төсөв төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын цалингаас 40 хувь буюу 478.8 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

5.2.4. Сумын Засаг даргын 2021 оны 01 сарын 19-ны өдрийн 3/13 тоот албан бичиг, 2023 оны 09 сарын 19-ны өдрийн 03/42 тоот албан бичгээр аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тооны захиалгыг хүргүүлсэн боловч орон тоо нөхөгдөөгүй тул Сумын ЗДТГ-ын даргын 2024 оны 5 сарын 1-ны өдрийн б/8 дугаар тушаалаар Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэнд Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнээр хавсруулан ажиллуулсан байна.

Энэ нь Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 сарын 16-ны өдрийн 40 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Сумын Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварын ажлын байранд тавигдах ерөнхий шаардлагуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

5.2.5. Тус Байгууллага нь дотоод хяналтын нэгжгүй, тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн харьяа байгууллага, аж ахуйн нэгж өөрийн аппаратад дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлнэ”, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.3-т “Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-тай байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

5.2.6. Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолоор сумын Засаг даргын тамгын газрын бүтэц орон тоо баталсан дээд хязгаараас үйлчилгээний 2 орон тоог илүү ажиллуулж цалин хөлс, нийгмийн даатгал шимтгэлд нийт 14,218.3 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоол, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” гэсний 4.1.3-д “Үр ашигтай байх”, 4.1.6 “Сахилга баттай байх”, 4.1.9 “Хариуцлагатай байх”, 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.2.чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийг урсгал зардлаар тайлагнасан	1	31,335.5			1	31,335.5	1	31,335.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
Санхүү албаны даргад үр дүнгийн урамшууллыг илүү олгосон байна.	1	478.8	1	478.8								
Малын үржил, бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэнд 6,555,8 мянган төгрөг, Байгаль орчны хяналтын улсын байцаагчид 6,555,8 мянган төгрөг нийт 22,577,859 төгрөгийг олгосноос хувь хүний орлогын албан татвар 2,257,785 төгрөгийг суутгаагүй байна.	1	2,257.8	1	2,257.8								
Малжуулах төслөөр олгосон зээлийн 11,980.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй хугацаа хэтрүүлсэн байна.	1	11,980.0			1	11,980.0						
Санхүү албаны даргад цалингийн сангаас нэг сарын үндсэн цалинтай тэнцэх 1,452.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг цалингаас сангаас олгосон байна.	1	1,452.0			1	1,452.0						
Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоог Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтнээр хавсруулан ажиллуулсан.	1				1							
Байгууллага нь дотоод хяналтын нэгжгүй, тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж ажиллаагүй.	1				1							

Архангай аймгийн Хашаат сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолоор баталсан дээд хязгаараас үйлчилгээний 2 орон тоо илүү ажиллуулсан.	1	14,218.3			1	14,218.3					
Нийт дүн	7	30,386.9	2	2,736.6	5	27,650.3					